

2022 ОНЫ ХОРТ ХАВДРЫН ӨВЧЛӨЛ, НАС БАРАЛТЫН ҮЗҮҮЛЭЛТ



Хорт хавдрын өвчлөл нас баралтын хураангуй, 2022 он

1. **ДЭМБ-ын статистик** мэдээллээр 2020 онд 19.2 сая гаруй хүн хорт хавдраад өвдөж, 9.9 сая хүн хорт хавдрын шалтгааны улмаас нас баржээ. Монгол улс дэлхийд хорт хавдрын нас баралтаараа нэгдүгээрт, элэгний хорт хавдрын өвчлөл, нас баралтаараа тэргүүлж байна.
2. **ДЭМБ-ын статистик** мэдээлэлд зонхилох байрлалын хорт хавдрын өвчлөлд хөх, түрүү булчирхай, уушиг, бүдүүн шулуун гэдэс, умайн хүзүүний хорт хавдрууд байна.
3. Монгол улсын хүн амын дунд **2022 онд 6885 хорт хавдрын шинэ өвчлөл** бүртгэгдсэн байна. Бүртгэгдсэн хавдрын 63.6%-ийг хоол боловсруулах замын эрхтэнүүдийн, 12.1%-ийг нөхөн үржихүйн эрхтэнүүдийн, 8%-ийг амьсгал ба цээжний хөндийн эрхтэн системийн хорт хавдрууд тус тус эзэлж байна.
4. 2022 онд зонхилон байрлалын **хорт хавдрын өвчлөлийн бүтцэд** элэгний хорт хавдар 33.2%, ходоодны хорт хавдар 17.1%, уушиг гуурсан хоолой хорт хавдар 7.6%, улаан хоолой 5.0%, умайн хүзүүний хорт хавдар 4.6%, нийт хорт хавдрын 67.5 хувийг дээрх хорт хавдрууд эзэлж байна.
5. **Эрэгтэйчүүдийн дунд** элэг, ходоод, уушиг гуурсан хоолойн, улаанхоолой, бүдүүн шулуун гэдэсний хавдар, **эмэгтэйчүүдийн дунд** элэг, ходоод, умайн хүзүү, хөх, бүдүүн шулуун гэдэсний хорт хавдар зонхилон эхний 5 байрлалд тохиолдож байна.
6. **Элэгний хорт хавдрын өвчлөлийн түвшин** аль ч хүйсэнд хамгийн өндөр буюу 100 000 эрэгтэй хүн амд 77.6 тохиолдол, эмэгтэй хүн амд 59.5 тохиолдол байна.
7. **75 хүртэлх насны 3 эрэгтэй тутмын 1, 5 эмэгтэй тутмын 1 нь хорт хавдарт өртөж байна.**
8. 2022 онд бүртгэгдсэн зонхилох 10 байрлалын хавдрын **32.3% нь эрт үе шатандаа, 67.7% нь хожуу үе** шатандаа оношлогджээ.
9. Хорт хавдар **эрэгтэй эмэгтэй хүйсэндээ 75** ба түүнээс дээш насныханд хамгийн өндөр (2251.5) бүртгэгдсэн байв.
10. 2022 онд хорт хавдрын өвчлөлийн улсын дундаж түвшин 206.1 байсан бөгөөд **Архангай аймаг** өвчлөлийн түвшингээрээ хамгийн өндөр (317.1), **Баян-Өлгий** аймаг хамгийн бага (148.4), 15 аймагт улсын дунджаас өндөр, 6 аймаг ба Улаанбаатар хотод улсын дунджаас бага үзүүлэлттэй гарсан байна.
11. **Бүсүүдийн хорт хавдрын өвчлөлийг** улсын дундажтай харьцуулахад баруун, зүүн, хангайн, төвийн бүсүүд улсын дунджаас өндөр, Улаанбаатар хотод бага үзүүлэлттэй гарсан байна.
12. **Хорт хавдрын шалтгаант нас баралт 2022 онд 4548** бүртгэгдсэн нь өмнөх оноос 11 тохиолдлоор буурчээ.



13. Хорт хавдрын шалтгаант нас баралтын **67.5%-ийг хоол боловсруулах замын эрхтэнүүдийн**, 11.4%-ийг амьсгал ба цээжний хөндийн эрхтэнүүдийн, 8.9%-ийг нөхөн үржихүйн эрхтэнүүдийн хорт хавдрууд тус тус эзэлж байна. Элэг ба ходоодны хавдрууд нийт нас баралтын 53.4%-ийг эзэлж байна.
14. 2022 онд зонхилох байрлалын хорт хавдрын шалтгаант нас баралтын **бүтцэд** элэгний хорт хавдар 36%, ходоодны хорт хавдар 17.4%, уушиг гуурсан хоолой хорт хавдар 10.6%, улаан хоолой 5.6%, бүдүүн шулуун гэдэс 3.8% нийт хорт хавдрын шалтгаант нас баралтын 73.4 хувийг дээрх байрлалын хорт хавдрууд эзэлж байна.
15. **Эрэгтэйчүүдийн дунд** элэг, ходоод, уушиг гуурсан хоолойн, улаанхоолой, нойр булчирхайн хорт хавдар, **эмэгтэйчүүдийн дунд** элэг, ходоод, умайн хүзүү, улаан хоолойн, хөхний хорт хавдрын шалтгаант нас баралт зонхилж байна.
16. Хорт хавдрын шалтгаант **нас баралтын түвшин**эрэгтэй 100 000 хүн амд 160 тохиолдол, эмэгтэй 100 000 хүн амд 113 тохиолдол, аль ч хүйсийн 100 000 хүн амд элэгний хорт хавдрын нас баралт өндөр байна.
17. Монгол улсад **2022 онд 0-19 насны 143** хүүхдэд хорт хавдрын шинэ тохиолдол бүртгэгдсэн бол хорт хавдрын шалтгааны улмаас **0-19 насны 49 хүүхэд** эндсэн байна.
18. 0-19 насны хүүхдийн хорт хавдрын өвчлөлийн бүтцэд лейкеми 36.4%, тархи мэдрэлийн 18.2%, яс мөгөөрсний 7%, миелома 5.6%, элэгний хорт хавдар 2.1%-ийг эзэлж байна.
19. Монгол улсад 2022 оны жилийн эцэст хорт хавдар оноштой 26347 хүн амьдарч байгаагийн 525 (нийт хяналтын 2 хувь) 0-19 насны хүүхэд байна. Хорт хавдрын хяналтад байгаа хүмүүсийн 43 хувь нь 5 ба түүнээс дээш жил амьдарч байна.



БҮЛЭГ 1. ХОРТ ХАВДРЫН ӨВЧЛӨЛ, 2022 ОН

1.1 Хорт хавдрын өвчлөл, бүтэц


2022 оны хорт хавдрын тайлангаар 6885 хорт хавдрын шинэ өвчлөл оношлогдсоны 3604 эрэгтэй, 3281 эмэгтэй байна. Үүний 58.4 хувь нь орон нутагт, 41.6 хувь нь нийслэл хотод оношлогджээ.

Нийт хорт хавдрын шинэ өвчлөлийг 2021 онтой харьцуулахад 904 тохиолдол буюу элэг (330-аар), ходоод (218-аар), бөөр (80-аар), уушиг гуурсан хоолой (75-аар), нойр булчирхай (62-оор), бүдүүн шулуун гэдэс (28-аар), умайн хүзүү (6-аар), хөх (5-аар), улаан хоолой (4-өөр) тус тус нэмэгдсэн бол өндгөвчний хорт хавдрын тохиолдол (26-аар) буурсан үзүүлэлттэй байна (Хүснэгт 1). 2022 оны хорт хавдрын өвчлөлийг өмнөх онтой (2021) харьцуулахад зонхилон тохиолдох хорт хавдрын өвчлөлийн бүтцэд мэдэгдэхүйц өөрчлөлтгүй байна (Зураг 1).

Хүснэгт 1. Хорт хавдрын өвчлөл, 2022 он

№	Хорт хавдар, төрөл	Бодит тоо, оноор		Өвчлөлийн зөрүү	
		2021 он	2022 он	Өссөн	Буурсан
1	Элэг	1956	2286	330	
2	Ходоод	963	1181	218	
3	Бөөр	152	232	80	
4	Уушиг, гуурсан хоолой	446	521	75	
5	Нойр булчирхай	162	224	62	
6	Бүдүүн шулуун гэдэс	278	306	28	
7	Умайн хүзүү	312	318	6	
8	Хөх	278	283	5	
9	Улаан хоолой	338	342	4	
10	Өндгөвч	144	118	0	26
11	Бусад хавдар	952	1074	122	
	Бүгд	5981	6885	904	

Зураг 1. Хорт хавдрын өвчлөлийн бүтэц, 2022 он





Нийт бүртгэгдсэн хорт хавдрын 63.6%-ийг хоол боловсруулах замын эрхтэнүүдийн, 12.1%-ийг нөхөн үржихүйн эрхтэнүүдийн, 8%-ийг амьсгал ба цээжний хөндийн эрхтэн системийн хорт хавдрууд тус тус эзэлж байна. Элэг, ходоодны хорт хавдрууд нийт шинээр бүртгэгдсэн хорт хавдрын 50%-ийг эзэлж байна.

Хүснэгт 2. Хорт хавдрын өвчлөл, зонхилох эхний 10 байрлал, нийт хавдар, хүйс, хувиар 2022 он


№	ХОРТ ХАВДАР, БҮГД			ЭРЭГТЭЙ			ЭМЭГТЭЙ		
	Хорт хавдрын байрлал	Т/тоо*	%	Хорт хавдрын байрлал	Т/тоо*	%	Хорт хавдрын байрлал	Т/тоо*	%
1	Элэг	2286	33.2	Элэг	1277	35.4	Элэг	1009	30.8
2	Ходоод	1181	17.1	Ходоод	797	22.1	Ходоод	384	11.7
3	Уушиг, гуурсан хоолой	521	7.6	Уушиг, гуурсан хоолой	400	11.1	Умайн хүзүү	318	9.7
4	Улаанхоолой	342	5.0	Улаанхоолой	194	5.4	Хөх	282	8.6
5	Умайн хүзүү	318	5.3	Бүдүүн шулуун гэдэс	144	4.0	Бүдүүн шулуун гэдэс	162	4.9
6	Бүдүүн шулуун гэдэс	306	4.6	Нойр булчирхай	125	3.5	Улаанхоолой	148	4.5
7	Хөх	283	4.1	Бөөр	111	3.1	Уушиг, гуурсан хоолой	121	3.7
8	Бөөр	232	3.4	Тархи мэдрэл	71	2.0	Бөөр	121	3.7
9	Нойр булчирхай	224	3.3	Лейкеми	63	1.7	Өндгөвч	118	3.6
10	Өндгөвч	118	1.7	Түрүү булчирхай	51	1.4	Нойр булчирхай	99	3.0
БҮГД		6885			3604			3281	

1.2 Хорт хавдрын өвчлөл, өвчлөлийн түвшин, өвчлөлийн стандартчилсан түвшин 2022 он

Хорт хавдрын өвчлөл нас ахих тусам нэмэгдэж хорт хавдрын өвчлөлийн түвшинг насны бүлгээр авч үзвэл нас ахих тусам хорт хавдрын өвчлөлийн түвшин тасралтгүй нэмэгдэн 75-аас дээш насныханд хамгийн өндөр буюу 100000 хүн амд 2251.5 тохиолдол байна (Зураг 2).




Зураг 2. Нийт хорт хавдрын тохиолдлын тоо, өвчлөлийн түвшин, Насны бүлгээр 100 000 хүн амд, 2022 он



Нийт хорт хавдрын өвчлөлийн түвшин (ӨТ)¹ 100 000 хүн амд 207.9 тохиолдол ногдож байгаа ба энэ үзүүлэлт эрэгтэйчүүдэд 219.0, эмэгтэйчүүдэд 193.6 байна. Элэг, ходоодны хорт хавдрууд өвчлөлийн түвшингээр эрэгтэй эмэгтэй хүйсэнд ялгаагүй эхний байранд орж байгаа ба эрэгтэй хүйсэнд уушиг гуурсан хоолой, улаан хоолой, бүдүүн шулуун гэдэсний хавдар эрэмблэгдэж, эмэгтэйчүүдийн хувьд умайн хүзүү, хөх, бүдүүн шулуун гэдэсний хавдрууд тус тус эрэмбэлэгдэж байна (Зураг 3, Хүснэгт 3).

Зураг 3. Зонхилох эхний 10 байрлалын хорт хавдар, ӨТ* хүйсээр, 100 000 хүн амд, 2022 он



Хүснэгт 3. Хорт хавдрын шинэ өвчлөлийн бодит тоо, эзлэх хувь, ӨТ, ӨСТ 2022 он

№	Хавдрын байрлал	Эрэгтэй					Эмэгтэй					Бүгд				
		ТТ	Эзлэх хувь	*ӨТ	ӨСТ (дэлхий)	ХТ	ТТ	Эзлэх хувь	*ӨТ	ӨСТ (дэлхий)	ХТ	ТТ	Эзлэх хувь	*ӨТ	ӨСТ (дэлхий)	ХТ
1	Уруул, амны хөндий	21	0.6	1.3	1.7	0.2	23	0.7	1.4	1.4	0.2	44	0.6	1.3	1.5	0.2
2	Бусад залгиур	23	0.6	1.4	1.8	0.2	9	0.3	0.5	0.5	0.0	32	0.5	1.0	1.1	0.1
3	Улаанхоолой	194	5.4	11.8	17.5	2.2	148	4.5	8.7	9.6	1.0	342	5.0	10.3	13.4	1.5
4	Ходоод	797	22.1	48.4	66.5	7.9	384	11.7	22.7	24.3	2.9	1181	17.2	35.7	43.3	5.1
5	Бүдүүн шулуун гэдэс	144	4.0	8.8	11.4	1.3	162	4.9	9.6	10.0	1.2	306	4.4	9.2	10.9	1.3
6	Элэг	1277	35.4	77.6	105.8	13.1	1009	30.8	59.5	65.7	8.1	2286	33.2	69.0	86.1	10.1
7	Цэсний хүүдий бусад	16	0.4	1.0	1.2	0.2	21	0.6	1.2	1.3	0.2	37	0.5	1.1	1.3	0.2
8	Нойр булчирхай	125	3.5	7.6	10.7	1.3	99	3.0	5.8	6.3	0.7	224	3.3	6.8	8.3	1.0
9	Төвөнх	29	0.8	1.8	2.7	0.4	4	0.1	0.2	0.3	0.0	33	0.5	1.0	1.3	0.2
10	Уушиг, гуурсан хоолой	400	11.1	24.3	36.5	4.5	121	3.7	7.1	7.8	0.9	521	7.6	15.7	20.1	2.5
11	Яс	26	0.7	1.6	1.9	0.2	23	0.7	1.4	1.3	0.1	49	0.7	1.5	1.7	0.1
12	Арьсны меланома	18	0.5	1.1	1.7	0.1	27	0.8	1.6	1.6	0.1	45	0.7	1.4	1.6	0.1
13	Хөх	1	0.0	0.1	0.1	0.0	282	8.6	16.6	16.1	1.8	283	4.1	8.5	8.9	1.1
14	Умайн хүзүү		0.0				318	9.7	18.8	17.7	1.9	318	4.6	9.6	9.8	1.1
15	Умайн их бие		0.0				49	1.5	2.9	2.8	0.3	49	0.7	1.5	1.6	0.2
16	Өндгөвч		0.0				118	3.6	7.0	7.1	0.8	118	1.7	3.6	4.0	0.5
17	Түрүү булчирхай	51	1.4	3.1	5.6	0.5		0.0				51	0.7	1.5	2.2	0.2
18	Төмсөг	13	0.4	0.8	0.8	0.1		0.0				13	0.2	0.4	0.4	0.0
19	Бөөр	111	3.1	6.7	8.0	0.9	121	3.7	7.1	7.3	0.8	232	3.4	7.0	7.8	0.9
20	Давсаг	37	1.0	2.2	3.1	0.4	11	0.3	0.6	0.7	0.1	48	0.7	1.4	1.8	0.2
21	Тархи, мэдрэлийн	71	2.0	4.3	5.0	0.5	44	1.3	2.6	2.8	0.3	115	1.7	3.5	3.9	0.4
22	Бамбай булчирхай	16	0.4	1.0	1.1	0.1	66	2.0	3.9	3.7	0.4	82	1.2	2.5	2.6	0.3
23	Ходжины өвчин	2	0.1	0.1	0.1	0.0	2	0.1	0.1	0.1	0.0	4	0.1	0.1	0.1	0.0
24	ХБЛимфома	29	0.8	1.8	2.2	0.2	20	0.6	1.2	1.2	0.1	49	0.7	1.5	1.7	0.2
25	Миелома	13	0.4	0.8	0.9	0.1	14	0.4	0.8	0.9	0.1	27	0.4	0.8	0.9	0.1
26	Лимфоид лейкеми	63	1.7	3.8	4.1	0.3	52	1.6	3.1	3.2	0.3	115	1.7	3.5	3.6	0.3
27	Бусад байрлал	127	3.5	7.7	10.5	1.2	154	4.7	9.1	9.2	0.9	281	4.1	8.5	9.9	1.0
28	Бүгд	3604	100.0	219.0	301.0	36.0	3281	100.0	193.6	203.2	23.5	6885	100.0	207.9	249.7	29.6

*2022 оны дундаж хүн ам



1.3 Хорт хавдрын өвчлөл, TNM үе шатаар


Олон улсад цусны, булчирхай, тархи, мэдрэлийн гаралтай хорт хавдраас бусад байрлалын хорт хавдрыг TNM ангилалыг баримтлан үе шатыг тогтоодог. TNM ангилалд хамаарах хорт хавдрын үе шатыг байрангаас 2 үе шатыг эрт үеийн хорт хавдар, 3 ба 4 үе шатыг хожуу үеийн хавдар хэмээж хувийг тооцсон.

2022 онд бүртгэгдсэн зонхилох 10 байрлалын хавдрын 32.3% нь эрт үе шатандаа, 67.7% нь хожуу үе шатандаа оношлогджээ (Хүснэгт 4). Зонхилох байрлалын хорт хавдруудаас уушиг гуурсан хоолойн (92.1%), нойр булчирхайн (86.6%), улаан хоолойн (82.2%) хорт хавдрууд ихэвчлэн хожуу үе шатандаа оноглогдож байгаа бол бөөр (63%), хөх (54.4%), умайн хүзүүний (52.8%) хорт хавдрууд харьцангуй эрт үе шатандаа оношлогджээ (Зураг 4).

Хүснэгт 4. Хорт хавдрын оношлогдох үеийн үе шат (TNM ангилал), 2022 он, хувиар

№	ХАВДРЫН БАЙРЛАЛ	БАЙРА Н	I ҮЕ	II ҮЕ	III ҮЕ	IV ҮЕ	ЭРТ ҮЕ	ХОЖУУ ҮЕ
1	Элэг	0.0	3.6	24.2	38.4	33.8	27.8	72.2
2	Ходоод	0.7	6.4	18.6	41.9	32.3	25.7	74.3
3	Уушиг, гуурсан хоолой	0.0	1.3	6.5	43.8	48.4	7.9	92.1
4	Улаанхоолой	0.0	4.1	13.7	53.8	28.4	17.8	82.2
5	Умайн хүзүү	6.0	12.3	34.6	37.4	9.7	52.8	47.2
6	Бүдүүн шулуун гэдэс	1.0	2.3	17.6	47.1	32.0	20.9	79.1
7	Хөх	3.9	12.7	37.8	34.6	11.0	54.4	45.6
8	Бөөр	0.4	33.9	28.6	25.1	11.9	63.0	37.0
9	Нойр булчирхай	0.0	0.9	12.5	36.6	50.0	13.4	86.6
10	Өндгөвч	2.5	8.5	28.8	37.3	22.9	39.8	60.2

Зураг 4. Зонхилох хорт хавдрын оношлогдох үеийн үе шат (эрт ба хожуу үе), 2022 он, хувиар



Зонхилон тохиолдох хорт хавдрын өвчлөлийн дундаж насыг тооцон үзвэл умайн хүзүүний хорт хавдар 51 нас, улаан хоолойн хорт хавдар хамгийн ахмад буюу 69 нас байна (Хүснэгт 5).



Хүснэгт 5. Зонхилон тохиолдох хорт хавдарт өртсөн дундаж нас, 2022 он

№	ХОРТ ХАВДАР, НИЙТ		ЭРЭГТЭЙ		ЭМЭГТЭЙ	
	Хорт хавдрын байрлал	Дундаж нас	Хорт хавдрын байрлал	Дундаж нас	Хорт хавдрын байрлал	Дундаж нас
1	Элэг	65	Элэг	62	Элэг	68
2	Ходоод	63	Ходоод	62	Ходоод	64
3	Уушиг, гуурсан хоолой	67	Уушиг, гуурсан хоолой	67	Умайн хүзүү	51
4	Улаанхоолой	69	Улаанхоолой	64	Хөх	53
5	Умайн хүзүү	51	Бүдүүн шулуун гэдэс	59	Бүдүүн шулуун гэдэс	62
6	Бүдүүн шулуун гэдэс	61	Нойр булчирхай	63	Улаанхоолой	73
7	Хөх	53	Бөөр	55	Уушиг, гуурсан хоолой	68
8	Бөөр	57	Тархи мэдрэл	43	Бөөр	58
9	Нойр булчирхай	63	Лейкеми	33	Өндгөвч	54
10	Өндгөвч	54	Түрүү булчирхай	78	Нойр булчирхай	63

Нийт хорт хавдраар өвчилсөн хүн амыг насаар бүлэглэн насны бүлэгт нь зонхилон тохиолдох хорт хавдрыг тооцон үзэхэд 0-14 насанд лимфойд лейкеми, 15-34 насанд ходоод, 35-64 ба 65-аас дээш насанд элэгний хорт хавдар хамгийн түгээмэл тохиолджээ (Хүснэгт 6).

Хүснэгт 6. Зонхилон тохиолдох хорт хавдар, насны бүлгээр, 2022 он


№	Тухайн насны бүлэгт	1-РТ	2-РТ	3-РТ	4-РТ	5-РТ	
1	0-14 нас	Зонхилох байрлал	Лимфойд лейкеми	Тархи мэдрэл	Миелома	Яс	Элэг
		ТТ	47	18	7	5	3
		ӨТ	4.3	1.7	0.6	0.5	0.3
2	15-34 нас	Зонхилох байрлал	Ходоод	Умайн хүзүү	Тархи мэдрэл	Өндгөвч/ Лейкеми	Элэг
		ТТ	36	29	16	15	13
		ӨТ	3.7	3.0	1.7	1.6	1.3
3	35-64 нас	Зонхилох байрлал	Элэг	Ходоод	Уушиг	Умайн хүзүү	Хөх
		ТТ	1227	653	260	238	232
		ӨТ	109.1	58.1	23.1	21.2	20.6
4	65 аас дээш нас	Зонхилох байрлал	Элэг	Ходоод	Уушиг	Улаан хоолой	Бүдүүн шулуун гэдэс
		ТТ	1043	492	259	190	117
		ӨТ	663.6	313,0	164.8	120.9	74.4



1.4 Хорт хавдрын өвчлөлийн түвшин, аймгуудаар

2022 онд хорт хавдрын өвчлөлийн улсын дундаж түвшин 206.1 тохиолдол ногдож Архангай аймаг өвчлөлийн түвшингээр хамгийн өндөр (317.1), Баян-Өлгий аймаг бага (148.4) үзүүлэлт гарсан байна(Зураг 5).

Зураг 5. Хорт хавдрын өвчлөлийн түвшин, аймгуудын 100000 хүн амд, 2022 он



Мөн Монгол улсын газар зүйн бүс нутгаар хорт хавдрын өвчлөлийг улсын дундажтай харьцуулахад баруун, зүүн, хангайн, төвийн бүсүүд улсын дунджаас өндөр, Улаанбаатар хотод бага үзүүлэлттэй гарсан байна.

Эмэгтэй хүйсийн хувьд Хангайн, Зүүн, Төвийн бүсэд улсын дунджаас өндөр, Баруун бүс, Улаанбаатар хотод улсын дунджаас бага үзүүлэлттэй, Эрэгтэй хүйсийн хувьд Хангайн, Баруун, Зүүн, Төвийн бүсэд улсын дунджаас өндөр, Улаанбаатар хотод улсын дунджаас бага үзүүлэлттэй байна (Хүснэгт 7).



Хүснэгт 7. Хорт хавдрын өвчлөлийн түвшин, аймгуудын 100000 хүн амд, бүсээр

Аймгууд	Нийт		Эрэгтэй		Эмэгтэй	
	ТТ	ӨТ	ТТ	ӨТ	ТТ	ӨТ
Баруун бүс	895	214.6	503	240.9	392	188.2
Баян-Өлгий	162	148.4	81	148.6	81	148.2
Говь-Алтай	135	230.8	78	266.2	57	195.2
Завхан	170	231.0	86	234.4	84	227.7
Увс	206	241.2	113	263.0	93	219.2
Ховд	222	245.3	145	319.6	77	170.6
Хангайн бүс	1887	232.9	1001	246.8	886	218.9
Архангай	303	317.1	147	306.7	156	327.5
Баянхонгор	154	171.5	80	180.8	74	162.4
Булган	130	210.3	72	228.9	58	190.9
Өвөрхангай	263	224.5	134	229.9	129	219.0
Орхон	262	246.7	140	268.4	122	225.9
Сэлэнгэ	237	218.6	125	227.2	112	209.8
Төв	229	244.6	136	282.7	93	204.4
Хөвсгөл	309	224.2	167	244.1	142	204.6
Төвийн бүс	652	206.6	346	219.5	306	193.9
Говьсүмбэр	28	154.7	11	122.0	17	187.1
Дархан-Уул	273	260.9	132	257.0	141	264.6
Дорноговь	122	169.5	72	198.2	50	140.3
Дундговь	88	185.8	51	214.2	37	157.1
Өмнөговь	141	192.0	80	215.3	61	168.1
Зүүн бүс	586	255.1	319	275.3	267	234.6
Дорнод	233	275.4	130	304.4	103	245.8
Сүхбаатар	176	268.6	102	310.1	74	226.8
Хэнтий	177	222.6	87	216.0	90	229.2
Улаанбаатар	2865	182.7	1435	189.4	1430	176.5
Улсын дундаж		206.1		219.0		193.6

*2022 оны аймгуудын дундаж хүн ам

БҮЛЭГ 2. ХОРТ ХАВДРЫН ШАЛТГААНТ НАС БАРАЛТ 2022 ОН


2.1 Хорт хавдрын нас баралт бүтэц

Монгол улсад 2022 онд 4548 хүн хорт хавдрын улмаас нас барсаны 2635 эрэгтэй, 1913 эмэгтэй байна.

Элэгний хорт хавдраар 1714 хүн нас барсан нь нийт нас баралтын 37% дангаараа эзэлж байна.

Нас баралтын зонхилох эхний 5 байрлалд элэг, ходоод, уушиг, улаан хоолой, умайн хүзүүний хорт хавдрууд байна. (Хүснэгт 5 зураг 6).

Зураг 6. Хорт хавдрын нас баралтын бүтэц 2022 он



Монгол улсад бүртгэгдсэн хорт хавдрын шалтгаант нас баралтын 67.5%-ийг хоол боловсруулах замын эрхтэнүүдийн, 11.4%-ийг амьсгал ба цээжний хөндийн эрхтэнүүдийн, 8.9%-ийг нөхөн үржихүйн эрхтэнүүдийн, хорт хавдрууд тус тус эзэлж байна.

Элэг ба ходоодны хавдрууд нийт бүртгэгдсэн хавдрын 53.4%-ийг дангаараа бүрдүүлжээ (Зураг 10. Хүснэгт 8).

Хүснэгт 8. Хорт хавдрын шалтгаант нас баралт, Зонхилох байрлалаар 2022 он

№	НАС БАРАЛТ, НИЙТ			ЭРЭГТЭЙ			ЭМЭГТЭЙ		
	Хорт хавдрын байрлал	Т/тоо*	%	Хорт хавдрын байрлал	Т/тоо*	%	Хорт хавдрын байрлал	Т/тоо*	%
1	Элэг	1636	36.0	Элэг	931	35.3	Элэг	705	36.9
2	Ходоод	793	17.4	Ходоод	572	21.7	Ходоод	221	11.6
3	Уушиг, гуурсан хоолой	480	10.6	Уушиг, гуурсан хоолой	391	14.8	Умайн хүзүү	146	7.6
4	Улаанхоолой	255	5.6	Улаанхоолой	152	5.8	Улаанхоолой	103	5.4
5	Бүдүүн шулуун гэдэс	172	3.8	Нойр булчирхай	100	3.8	Хөх	97	5.1
6	Нойр булчирхай	170	3.7	Бүдүүн шулуун гэдэс	92	3.5	Уушиг, гуурсан хоолой	89	4.7
7	Умайн хүзүү	146	3.2	Тархи, мэдрэлийн	57	2.2	Өндгөвч	88	4.6
8	Хөх	97	2.1	Бөөр	53	2.0	Бүдүүн шулуун гэдэс	80	4.2
9	Тархи, мэдрэл	96	2.1	Лейкеми	33	1.3	Нойр булчирхай	70	3.7
10	Өндгөвч	88	1.9	Түрүү булчирхай	31	1.2	Тархи, мэдрэл	39	2.0
	Бүгд	4548		Бүгд	2635		Бүгд	2026	

2.2 Хорт хавдрын нас баралт, нас баралтын стандартчилсан түвшин


Хорт хавдрын нас баралтын түвшин (НБТ) 100 000 хүн амд 136.0 тохиолдол, эрэгтэй 100 000 хүн амд 160.1 тохиолдол, эмэгтэй 100 000 хүн амд 112.9 тохиолдол ногдож байна (Хүснэгт 9).

Хүснэгт9. Хорт хавдрын нас баралт, эзлэх хувь, НБТ, НБСТ 2022он

№	Хавдрын байрлал	Эрэгтэй				Эмэгтэй				Бүгд			
		ТТ	%	*НБТ	НБСТ	ТТ	%	*НБТ	НБСТ	ТТ	%	*НБТ	НБСТ
1	Уруул, амны хөндий	21	0.7	1.3	1.8	11	0.4	0.6	0.7	32	0.5	1.0	1.2
2	Бусад залгиур	16	0.5	1.0	1.3	11	0.4	0.6	0.7	27	0.5	0.8	0.9
3	Улаанхоолой	152	4.9	9.2	14.3	103	3.6	6.1	6.8	255	4.3	7.6	9.9
4	Ходоод	572	18.3	34.8	51.2	221	7.8	13.0	14.5	793	13.3	23.7	29.7
5	Бүдүүн шулуун гэдэс	92	2.9	5.6	8.0	80	2.8	4.7	4.9	172	2.9	5.1	6.2
6	Элэг	931	29.7	56.6	78.4	705	24.7	41.6	46.3	1636	27.4	49.0	60.7
7	Цэсний хүүдий бусад	10	0.3	0.6	0.7	15	0.5	0.9	0.9	25	0.4	0.7	0.9
8	Нойр булчирхай	100	3.2	6.1	8.5	70	2.5	4.1	4.4	170	2.8	5.1	6.1
9	Төвөнх	17	0.5	1.0	1.7	4	0.1	0.2	0.3	21	0.4	0.6	0.9
10	Уушиг,гуурсан хоолой	391	12.5	23.8	36.3	89	3.1	5.3	5.9	480	8.0	14.4	18.3
11	Яс	20	0.6	1.2	1.4	20	0.7	1.2	1.2	40	0.7	1.2	1.3
12	Арьсны меланома	13	0.4	0.8	1.4	21	0.7	1.2	1.3	34	0.6	1.0	1.4
13	Хөх	0	0.0	0.0	0.0	97	3.4	5.7	5.8	97	1.6	2.9	3.3
14	Умайн хүзүү	0	0.0	0.0	0.0	146	5.1	8.6	9.2	146	2.4	4.4	5.3
15	Умайн их бие	0	0.0	0.0	0.0	22	0.8	1.3	1.4	22	0.4	0.7	0.8
16	Өндгөвч	0	0.0	0.0	0.0	88	3.1	5.2	5.5	88	1.5	2.6	3.1
17	Түүрүү булчирхай	31	1.0	1.9	3.2	0	0.0	0.0	0.0	31	0.5	0.9	1.2
18	Төмсөг	6	0.2	0.4	0.4	0	0.0	0.0	0.0	6	0.1	0.2	0.2
19	Бөөр	53	1.7	3.2	4.8	26	0.9	1.5	1.8	79	1.3	2.4	3.0
20	Давсаг	10	0.3	0.6	1.0	3	0.1	0.2	0.2	13	0.2	0.4	0.5
21	Тархи, мэдрэлийн	57	1.8	3.5	4.6	39	1.4	2.3	2.4	96	1.6	2.9	3.4
22	Бамбай булчирхай	4	0.1	0.2	0.3	11	0.4	0.6	0.7	15	0.3	0.4	0.6
23	Ходжкины өвчин	1	0.0	0.1	0.1	2	0.1	0.1	0.1	3	0.1	0.1	0.1
24	Ходжкины бус лимфома	17	0.5	1.0	1.3	10	0.4	0.6	0.7	27	0.5	0.8	1.0
25	Миелома	7	0.2	0.4	0.6	4	0.1	0.2	0.3	11	0.2	0.3	0.4
26	Лимфоид лейкоми	33	1.1	2.0	2.2	33	1.2	1.9	1.9	66	1.1	2.0	2.0
27	Бусад байрлал	81	2.6	4.9	7.3	82	2.9	4.8	4.9	163	2.7	4.9	5.9
28	Бүгд	2635	84.2	160.1	230.8	1913	67.1	112.9	123.0	4548	76.0	136.0	168.3


*2022 оны дундаж хүн ам

Зураг 7. Зонхилон тохиолдох хорт хавдрын НБСТ, хүйсээр 100 000 хүн амд, 2022 он



2022 онд хорт хавдрын шалтгаант нас баралтын түвшинг насны бүлгээр авч үзвэл нас ахих тусам нас баралтын түвшин тасралтгүй нэмэгдэн 75-аас дээш насныханд хамгийн өндөр буюу 100000 хүн амд 2178.7 тохиолдол байжээ (Зураг 7).

Зураг 8. Хорт хавдрын шалтгаант нас баралтын насаар өвөрмөц түвшин, хүйсээр 2022 он



Хорт хавдрын шалтгаант зонхилон тохиолдох хорт хавдрын нас барсан дундаж насыг тооцоход тархи мэдрэлийн хавдар 52 нас, улаан хоолойн хорт хавдар 71 нас байна (Хүснэгт 10).



Хүснэгт 10. Зонхилон тохиолдох хорт хавдраар нас барсан дундаж нас, 2022 он

№	ХОРТ ХАВДАР, НИЙТ		ЭРЭГТЭЙ		ЭМЭГТЭЙ	
	Хорт хавдрын байрлал	Дундаж нас	Хорт хавдрын байрлал	Дундаж нас	Хорт хавдрын байрлал	Дундаж нас
1	Элэг	67	Элэг	63	Элэг	72
2	Ходоод	67	Ходоод	65	Ходоод	70
3	Уушиг, гуурсан хоолой	68	Уушиг, гуурсан хоолой	67	Умайн хүзүү	62
4	Улаанхоолой	71	Улаанхоолой	68	Улаанхоолой	76
5	Бүдүүн шулуун гэдэс	65	Нойр булчирхай	64	Хөх	60
6	Нойр булчирхай	66	Бүдүүн шулуун гэдэс	64	Уушиг, гуурсан хоолой	70
7	Умайн хүзүү	62	Тархи мэдрэл	50	Өндгөвч	62
8	Хөх	60	Бөөр	66	Бүдүүн шулуун гэдэс	68
9	Тархи мэдрэлийн	52	Лейкеми	38	Нойр булчирхай	67
10	Өндгөвч	62	Түүрүү булчирхай	77	Тархи мэдрэл	54

БҮЛЭГ 3. ХҮҮХДИЙН Х ОРТ ХАВДРЫН ТУХАЙ (0-19 нас)

3.1 Хүүхдийн хорт хавдрын өвчлөл

Монгол улсад 2022 онд 0-19 насанд 143 хорт хавдрын шинэ өвчлөл бүртгэгдсэн байна. Үүний 53.1% (76) хөвгүүд, 46.9% (67) охид байна. 0-19 насны хүүхдийн хорт хавдрын өвчлөлийн бүтцэд лейкеми тэргүүлж байгаа ба тархи мэдрэлийн, яс мөгөөрсний, миелома, элэг, ходжкины бус лимфома хавдрууд удаалж байна (Зураг 9).

Зураг 9. Хүүхдийн хорт хавдрын бүтэц, хувиар 0-19 нас




2022 онд 0-14 насныханд лимфойд лейкеми, 15-19 насныханд тархи мэдрэлийн хавдрууд хамгийн өндөр тохиолджээ (Хүснэгт 11).

Хүснэгт 11. Насны бүлэгт зонхилон тохиолдох хорт хавдар, тохиолдлын тоо, 100 000 хүүхдэд 2022 он

№	НАСНЫ БҮЛЭГ		1-РТ	2-РТ	3-РТ	4-РТ	5-РТ
1	0-4 нас	Зонхилох байрлал	Лимфойд лейкеми	Миелома	Тархи мэдрэл	Элэг	ХБЛ
		ТТ	21	6	4	3	2
		ӨТ	5.6	1.6	1.1	0.8	0.5
2	5-9 нас	Зонхилох байрлал	Лимфойд лейкеми	Тархи мэдрэл	Миелома/Яс	Бусад	
		ТТ	14	10	3		
		ӨТ	3.6	2.6	0.3		
3	10-14 нас	Зонхилох байрлал	Лимфойд лейкеми	Тархи мэдрэл	Ходжкин лимфома	Бусад	
		ТТ	12	4	1		
		ӨТ	3.7	1.2	0.3		
4	15-19 нас	Зонхилох байрлал	Тархи мэдрэл	Яс	Нойр булчирхай	Бусад	
		ТТ	8	5	2		
		ӨТ	3.6	2.3	0.9		

Хүүхдийн хорт хавдрын өвчлөл 0-4 насны хүүхдүүдэд тохиолдлын тоо хамгийн өндөр (52), 5-9 насанд бага (26) байгаа ч 100 000 хүүхдэд ногдох өвчлөлийн түвшинг тооцоход 15-19 насанд хорт хавдрын өвчлөлийн түвшин өндөр 16.2 тохиолдол байна (Зураг 10)


Зураг 10. Хүүхдийн хорт хавдрын тохиолдлын тоо, өвчлөлийн түвшин



3.2 Хүүхдийн хорт хавдрын нас баралт

2022 онд хорт хавдрын шалтгаанаар 0-19 насны 49 хүүхэд нас барсан байна. 0-19 насны хүүхдүүдийн хорт хавдрын шалтгаант нас баралтад лейкеми (44.9%), тархи мэдрэлийн (34.7%) хорт хавдрууд зонхилж байна (Зураг 11)


Зураг 11. Хүүхдийн хорт хавдрын нас баралтын бүтэцхувиар, 0-19 нас



Хүүхдийн хорт хавдрын шалтгаант нас баралт 5-9 насны хүүхдэд тохиолдлын тоо хамгийн өндөр (16), 10-14 насанд бага (9) байгаа ч 100 000 хүүхдэд ногдох нас баралтын түвшинг тооцоход 15-19 насан хамгийн өндөр (4.5) тохиолдол ногдож байна (Зураг 12).



**Зураг 12. Хүүхдийн хорт хавдрын тохиолдлын тоо,
нас баралтын түвшин**




БҮЛЭГ 4. ХОРТ ХАВДРЫНХЯНАЛТЫН ТУХАЙ

Монгол улсад 2022 оны жилийн эцсийн тайлангаар 26347 хүн хорт хавдрын оноштойгоор аймаг дүүргийн хавдар судлаач их эмчийн хяналтад байгаагийн 36.7% (9660) нь эрэгтэй, 63.3%(16687) нь эмэгтэйчүүд байна. 0-19 насны 525 хүүхэд хорт хавдрын улмаас хяналтад байгаагийн 302 (57.5%) эрэгтэй, 223(42.5%) охидууд байна.


Хорт хавдрын хяналтад байгаа хүмүүсийн 45.5%-ийг хоол боловсруулах замын эрхтэнүүдийн, 31%-ийг нөхөн үржихүйн эрхтэнүүдийн хорт хавдрууд тус тус эзэлж байна. Элэгний хорт хавдар 23%, умайн хүзүүний хорт хавдар 17%, ходоодны хорт хавдар 13.2%-ийг эзэлж байна(Зураг 13).

Зураг 13. Хорт хавдрын хяналт, бүтэцээр 2022 он



Хорт хавдар анх оношлогдож хяналтад орсон хугацааг он сар өдрөөр нь амьдарч буй жилүүдийг тооцоход 1 хүртэл жил дотроо 25%, 1-2 жил 10%, 2-3 жил 8%, 3-4 жил 7%, 4-5 жил 7%, 5-аас дээш жил 43% -ийг тус тус эзэлж байна. (Зураг 14).

Зураг 14. Хорт хавдрын хяналт, амьдарчбуй хугацаа (Жилээр) 2022 он





Хорт хавдрын хяналтад орсоноос хойш 5 ба түүнээс дээш жил амьдарсан хувийг зонхилох байрлалын хорт хавдруудаар тооцоход умайн хүзүүний хорт хавдар 62%-тай байгаа нь бусад байрлалын хорт хавдруудаас өндөр үзүүлэлттэй байна (Зураг 15).

Зураг 15. Хорт хавдрын хяналт, 5 ба түүнээс дээш жил амьдарч байгаа хүмүүсийн эзлэх хувь, зонхилох байрлалаар 2022 он

